

СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН ЭМНЭЛГЭЭР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭЭС АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

/2022 оны 1-11 сар /

2022.11.18

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг ЭМСайдын 2021оны 09дүгээр сарын 15-ны өдрийн А/578 тоот “Журам батлах тухай” шинэчлэгдсэн тушаалын дагуу эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч болон амбулаториор үйлчлүүлэгсдээс 31 асуумжийн дагуу сэтгэл ханамжийн судалгааг 2022 оны 1-11 сард авсан. Судалгаанд хэвтэн эмчлүүлэгч 626, амбулаториор үйлчлүүлсэн 348 иргэд хамрагдсан. Судалгааны нийт 31 асуумжийг 4 хэсэгт багцалж, 8 төрлийн асуумжийг голчлон авч дүгнэлт хийсэн.

Сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр хийсэн ажлын товч тайлан:

1. Хүлээгдлийн хугацааг богиносгох зорилгоор:

Судалгаанаас дүгнэхэд хүлээгдлийн дундаж хугацаа 5-30 минут байна. Амбулаторийн хүлээгдлийн 58,8%, хэвтэн эмчлүүлэгчдийн 29,9% 30-с дээш минут байна.

- Амбулаторийн хэсэгт нэг цэгийн үйл ажиллагааг нэвтрүүлж 2 чиглүүлэгч эмчийг орон тоогоор ажиллуулж байна. Мөн үйлчлүүлэгч лабораторийн шинжилгээний хариугаа заавал тодорхой цагт авахыг хүлээхгүйгээр хүссэн цагтаа Киоск машинаас өөрөө хэвлэн авах боломжоор хангасан.



- Хэвлийн эхо үзлэгийн кабинетыг нэмэгдүүлж 2 кабинет ажиллаж байна.
- Үзлэгийн цагийг үйлчлүүлэгч утсаар болон биеэр ирж авах боломжийг бүрдүүлж цахим бүртгэлээс гадна утасны оператор ажиллаж өөрөө ирэх боломжгүй иргэдэд 72728282 дугаарын утсаар үзлэгийн цаг олголтын

үйлчилгээ үзүүлж байна. 2-р амбулаторийн үйл ажиллагааг нэгтгэсэнтэй холбоотой утсаар цаг авах үйлчилгээ, цахим бүртгэлийн үйл ажиллагааг салбар амбулаторитой холбосон.

- Улирлын өвчлөлтэй холбоотой ачааллын үед амбулаторийн хүүхдийн үзлэгийн кабинетийг амралтын өдрүүдэд ажиллуулсан.
- СХНЭ-т хүүхдийн орны ачааллыг 200-с 300 болгон нэмэгдүүлсэн ч өдөрт 370-380 хүрч байсан. Иймд СХД-н зарим хороодын хэвтүүлэн эмчлүүлэх шаардлагатай хүүхдүүдийг ЭНҮТ-2-т хэвтүүлж эмчлүүлэхээр зохион байгуулалт хийсэн.
- Хүүхдийн жижүүр эмчийг ажлын өдрүүдэд 1, амралтын өдрүүдэд нэмэлтээр 1 эмчийг ажиллуулж байна.
- Ажлын өдрүүдэд 16:30-21:30, амралтын өдрүүдэд 09:30-21:30 цагуудад нэмэлтээр 2 эмч эмнэлгийн мэргэжилтэнг цахим бүртгэл, эрэмбэлэн ангилалтанд ажиллуулахаар зохион байгуулсан
- Хэвтэн эмчлүүлэх шаардлагатай өвчтөний өвчний түүхийг бага эмч нээдэг болгож бага эмчийн орон тоог нэмэгдүүлсэн.
- Ходоодны дурангийн эмчийн үзлэгийн орон тоог нэмэгдүүлж 2 эмч ажиллаж байна. Эрт илрүүлгийн үзлэгтэй холбоотой амралтын өдөр ходоодны дуран оношлогоог нэмэлтээр ажиллуулж байна.
- Үйлчлэх хороодын хүн амын тоо нэмэгдсэнтэй холбоотой дүрс оношлогоо, лаборатори, мэс засал, мэдээгүйжүүлгийн эмч нарыг 24 цагаар ажилладаг болгосон.
- Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвийг нээн ажиллуулж байна.
- Шүдний эмчийн үзлэг, кабинетын тоог нэмэгдүүлж нийт 3 кабинет ажиллаж байна.
- Насанд хүрэгчдийн хүлээн авах яаралтай тусламжийн тасгийг шинээр нэмэгдүүлж 24 цагийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

- 2022 оны 9-р сараас эхлэн Яаралтай мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлж эхэлсэн.

1. Орчин нөхцөл, тав тухтай орчин бүрдүүлэх талаар:

- Хэвтэн эмчлүүлэгчдийг агаарт гарч, амарч суухад тохь тухтай орчиныг бүрдүүлж хэвтэн эмчлүүлэх тасгийн террас дээр цэцэгжүүлж, орчныг цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийдэг.




- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч нарын эргэлтийн цагийн хуваарийг гаргаж, тасаг бүрт зориулсан эргэлтийн хэсэг гарган, үйлчлүүлэгчийн ар гэрт эргэлтийн хаалганы хаягийг тодорхой болгож, заасан чиг чиглэлийг ойлгомжтой хэлбэрээр хийсэн.




- Дэмжих төвийн үйл ажиллагаа хуучин эмнэлгийн байранд явагдах болсонтой холбоотой эмч ажилчдын ажиллах орчиныг сайжруулах, үйлчлүүлэгчдийн тав тухтай орчинд үйлчлүүлэх боломжийг хангах үүднээс үзлэгийн өрөө тасалгаа, хүлээлгийн танхим болон бусад дотоод засварыг хийж, дээврийн засвар

сүүлийн 10 жил хийгдээгүй дусаал гоожиж байсныг нээлттэй тендер шалгаруулалт зарлаж сонгон шалгаруулалт хийсний үндсэн дээр 77,550,000 сая төгрөгний төсөвт өртөгтэй засварын ажил гүйцэтгүүлж хийж ард иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хэвийн үзүүлж байна.





Амбулаторийн тасагт:

- Үйлчлүүлэгчийн тав тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор амбулаторийн хүлээлгийн танхимд ус цэвэршүүлэгч 2 ш-г байршуулсан.



- Кабинет бүрт унах эрсдлийг үнэлэх, эрэмбэлэн ангилалтын самбарыг эмнэлгийн ажилтан бүр ашиглахад хялбар дөхөм байршуулж ашиглах нөхцлөөр хангасан



- Кабинет бүрийн гадна дуугүй мэдээллийн самбар, үзлэгийн цагийн дарааллыг мэдээлэх дэлгэц байршуулж үйлчлүүлэгчдэд кабинетын үзлэгийн тодорхой мэдээллийг авах боломжоор хангасан.



- Үйлчлүүлэгчээс санал хүсэлт, гомдол хүлээн авах хайрцагийг дүрс оношлогоо, цахим бүртгэл, нөхөн үржихүйн кабинет, нэг цэгийн үйлчилгээний хэсэгт байршуулж сар улирал тутамд дүгнэлт хийж ажилладаг.



- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэвтэн эмчлүүлэх болон амбулаторийн хэсэгт эмнэлгийн хэмжээнд ээлтэй орчинг бүрдүүлсэн.



- 2-р амбулаторын сантехникийн шугам хоолой, халаах хэрэгсэлд засвар хийсэн, 35 ширхэг тохируулах хаалт, 25м босоо шугам шинээр сольж дотоод засвар үйлчилгээг хийж иргэдэд үйлчлүүлэх тав тухыг хангасан.



2. Эмч, сувилагч нарын харьцаа хандлагын талаар


2022 онд байгууллагын нийт ажиллагсадын харьцаа хандлага, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилгоор:

- 2022.02.28-ны өдөр ЭМЯ-ны анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны дарга АШУ-ны доктор, профессор Д. Цэрэндагва “ Ёс зүйн гурвалжин ба хувь хүний нууц ” сэдэвт сургалт
- Ёс зүйн хэсгийн хороо болон өдрийн эмчилгээний тасгаас хамт олны дунд СХНЭ-н 40 жилийн ойн хүрээнд “Байгууллагын түүхийг хэн сайн мэдэх вэ” хөгжөөнт АХА тэмцээн
- Байгууллагын нийт эмч сувилагч нийт ажилтан албан хаагчдын дунд хамгийн ёс зүйтэй ажилчдыг санал асуулгаар шалгаруулан хамт олны дунд үлгэр дуурайлал болгох ажлыг зохион байгуулсан.
- АШУҮИС Био анагаахын сургууль Харилцааны ур чадварын тэнхимийн багш АУ доктор профессор С.Наранчимэг "ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАР" сэдэвт сургалт 2022 оны 05 сарын 9, 11-ны өдрүүдэд
- Сэтгэл судлаач лектор Х.Баярсайхан Эмнэлгийн мэргэжилтний харьцаа хандлага сэдэвт сургалт 2022оны 5 сарын 26 ны өдөр тус тус явуулсан.
- “Инээмсэглэе, мэндлэе, талархяя” сэдэвт 6 сарын аяныг 2022.06.01-нээс 12.01 хүртэл зохион байгуулж ажиллаж байна.

3. Цэвэрлэгээ үйлчилгээний талаар:

Цэвэрлэгээ үйлчилгээний талаар дараах ажлуудыг тус тус хийсэн. Үүнд:

- 2022 оны 2 сард амбулаторийн тасгаас ” Хөөстэй угаалга”
- 2022 оны 4 сарын 20-нд “Их цэвэрлэгээ 90минут”
- Байгууллагын хэмжээнд улирал бүр их цэвэрлэгээний өдрүүд товлож дотно болон гадаад цэвэрлэгээ үйлчилгээг хийдэг.




- Байгууллагын орчиныг хамарсан ойр орчимын 50м талбайг нийт ажилчдыг хамруулан улирал бүрт цэвэрлэгээ хийдэг.



- 2022 оны 5 сарын 19-нд ХСХА-с зарласан удирдамжийн дагуу “урин дулааны цаг ирлээ-урсгал цэвэрлэгээгээ бүгдээрээ хийцгээе ”




- Цаг үеийн халдварт өвчний дэгдэлттэй холбоотой нэмэлт ор дэлгэх үйл ажиллагааг зохион байгуулж тухай бүрт нь хуучин эмнэлгийн байранд ор дэлгэхээс өмнө, буулгах тохиолдол бүрт их цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийг хийж ажилладаг.



- Байгууллагын 1000 гаруй метр квадрат талбайн өндөрийн болон гадна шилэн хэсгийн цэвэрлэгээг “Нандин хэлхээ ХХК” -аар хийлгэхээр гэрээний хэсэг явагдаж байна.

4. Ерөнхий сэтгэл ханамжийн талаар:

Үйлчлүүлэгчдийн Эмнэлгийн тусламж үйлчилгээний эерэг сэтгэл ханамжийн дундаж хувь амбулатори-76,5% хэвтэн эмчлүүлэх тасаг -81,7% байна. эерэг сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ -79,1%



ХЯНАСАН:

ЭМНЭЛЗҮЙ ЭРХЭЛСЭН ДЭД

ЗАХИРАЛ Д. СҮНЖИДМАА

ТАЙЛАН БИЧСЭН:

ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН Л. ЦЭВЭЛМАА